



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 04 сарын 18 өдөр

Дугаар 169

Улаанбаатар хот

“Зам, тээврийн хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин болон Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний биелэлтийн тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 65 дугаар зүйл, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 184 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн өмчит хуулийн этгээдийн захиралтай Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулах, дүгнэх журам”-ын 2.1, 3.1, 3.10, 4.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Зам, тээврийн хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин болон Захирал Х.Пүрэвжаргалтай байгуулсан Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний биелэлтийг “Сайн” гэж дүгнэсүгэй.

2.“Зам, тээврийн хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын Захирал Х.Пүрэвжаргалтай Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулах зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга Ц.Баяр-Эрдэнэд үүрэг болгосугай.

3.“Зам, тээврийн хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг ханган биелүүлж, 2023 оны Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний биелэлт “Сайн” гэж дүгнэгдсэн тул захирал Х.Пүрэвжаргалд хавсралтад заасны дагуу урамшуулал олгосугай.

4.Захирал Х.Пүрэвжаргалд хавсралтын дагуу олгох урамшууллыг холбогдох эх үүсвэрээс гаргахыг “Зам, тээврийн хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын Ерөнхий нягтлан бодогч Б.Дуламхандад зөвшөөрсүгэй.

5.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Б.ЦЭНГЭЛ,

Бодлого
Зохицуулалт

Хэлтэсийн

Хэлтэс

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

132001300
11-r huraldaan.docx



Төрийн өмчийн бодлого, зочижуулалтын газрын
2024 оны 04 дугаар сарын 18-ны өдрийн
169. дугаар тонноголын хавсралт

"ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ" ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ЗАХИРАЛД
2023 ОНЫ АЖЛЫН ҮР ДҮНГЭЭР ОЛГОХ УРАМШУУЛАЛ

Д/д	Хуулийн этгээдийн нэр	Захирлын нэр	Цэвэр ашиг /мян.төг/	Цэвэр ашигийн дунгээс хасаж тооцох валютын ханшийн өөрчлөлтөөс отсон ашиг алдагдал /мян.төг/	Урамшуулал тооцох цэвэр ашиг /мян.төг/	Олгох урамшууллын хэмжээ /төг/
1	"Зам, Тээврийн хөгжлийн төв" ТӨҮГ	Х.Пүрэвжаргал	228,244.60	0.0	228,244.60	9,564,890.00 (Есөн сая, таван зуун жаран дөрвөн мянга, найман зуун ерэн төгрөг)